

ТӨГРӨГИЙН ХУДАЛДАН АВАХ ЧАДВАР БА ӨРХИЙН МӨНГӨН ОРЛОГО, ЯДУУРЛЫН ШУГАМЫН БОДИТ ӨСӨЛТ

*Б.Батмөнх (Ph.D), профессор, Статистикийн тэнхим,
Эдийн засгийн сургууль, Монгол Улсын Их Сургууль*

Хураангуй

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллийн гол зорилго нь төгрөгийн дотоодын худалдан авах чадварыг олон улсын стандарт арга зүйгээр тооцож, түүнийг үндэслэн 1990-2011 оны өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг зэрэгцүүлэх үнээр үнэлж, түүний бодит өсөлтийг тооцож үнэлгээ өгөх явдал юм. Хүн амын ядуурлын түвшинг тодорхойлоход суурь болдог ядуурлын шугамын тооцоо үндэслэл муутай хийгдэж ирсэн ноцтой асуудлыг хөндөн тоо баримтаар нотлон харуулж, улмаар ҮСХ-ноос зарласаар ирсэн хүн амын амьжиргааны доод түвшинг дахин засварлаж зарлах, ядуурлын үзүүлэлтүүдийн 2005 оноос хойшхи тооцоог эргэж нягтлан үзэхийг санал болгосон.

Түлхүүр үгс: Төгрөгийн худалдан авах чадвар- Purchasing Power of Mongolian national currency, Ядуурлын шугам- Poverty line

1. Төгрөгийн дотоодын худалдан авах чадварын тооцоо

Үндэсний мөнгөн тэмдэгтийн дотоодын худалдан авах чадварын өөрчлөлт нь үнийн өөрчлөлтийн эсрэг өөрчлөлт байдаг. Бараа, бүтээгдэхүүний дундаж үнэ өсөхөд, тухайн хэмжээний мөнгөөр худалдан авах зүйлс тэр хэмжээгээр буурна эсвэл үнэ буурахад, тухайн хэмжээний мөнгөөр худалдан авах зүйлс тэр хэмжээгээр нэмэгддэг билээ. Үүнийг тооцохын тулд дотоодын хэрэглэгчид буюу дотоодын ойлголт тодорхойлолтод үндэслэсэн хэрэглээний үнийн индексийг (ХҮИ) ашигладаг. Ийм үзүүлэлтийг байнга тооцох нь судалгаа шинжилгээний чухал ач холбогдолтой байдаг.

Нэг жилийн хугацаанд үндэсний мөнгөн тэмдэгтийн дотоодын худалдан авах чадварын өөрчлөлтийг, өмнөх оныг суурь болгон 100-тай тэнцүү байсан гэж үзвэл, дараах томъёогоор тооцно. Үүнд:

$(\text{Өмнөх оны ХҮИ} / \text{Дараагийн оны ХҮИ}) * 100$

Үүнийг дараах бодит жишээг сонгон харуулъя. 2010 оны ХҮИ-ийн жилийн дундаж өөрчлөлт 2011 оны статистикийн эмхтгэлд 10,1 хувь, харин 2011 оны ХҮИ-ийн дундаж өөрчлөлт 9,2 хувийн өсөлттэй гарчээ. Одоо төгрөгийн худалдан авах чадварыг тодорхойлбол:

$$110,1/109,2*100= 100,8 \text{ болно.}$$

Өөрөөр хэлбэл, тухайн 2011 онд үндэсний мөнгөн тэмдэгтийн дотоодын худалдан авах чадвар (100-100,8) 0,8 хувиар нэмэгдсэн гэсэн үг. Хүртвэр, хуваарь 2-ыг сольсны дараа 2010 онд 100 төгрөгөөр авч байсан зүйлийг 2011 онд 99,2 төгрөгөөр (109,2/110,1*100= 99,2) авна гэсэн үг юм.

1990-2012 оны 11 сарыг дуустал хугацаагаар жил бүрийн хэрэглээний үнийн индексийг хэрэглээний үнэ, төгрөгийн худалдан авах чадварын хэлхээ индекс болон суурь үетэй харьцуулсан индексийн тооцоог Хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1. Хэрэглээний үнийн болон төгрөгийн худалдан авах чадварын хэлхээ болон суурь үетэй харьцуулсан индексүүд

Он	Хэрэглээний үнийн жил бүрийн өсөлтийн индекс (ХҮИ)	Суурь 1990 онтой харьцуулсан ХҮИ, 1990=1	Өмнөх онтой харь-цуулсан төгрөгийн дотоодын худалдан авах чадварын индекс	Суурь 1990 онтой харьцуулсан төгрөгийн дотоодын худалдан авах чадварын индекс, 1990=1
1990	1	1	1	1
1991	1,527	1,527	0,655	0,655
1992	4,25	6,49	0,359	0,154
1993	2,83	18,367	1,502	0,0544
1994	1,663	30,543	1,702	0,0327
1995	1,531	46,763	1,086	0,0214
1996	1,446	67,62	1,059	0,0148
1997	1,205	81,48	1,200	0,0123
1998	1,06	86,37	1,137	0,0116
1999	1,1	95,01	0,964	0,0105
2000	1,081	102,7	1,018	0,0097
2001	1,08	110,92	1,001	0,0090
2002	1,016	112,69	1,063	0,0089
2003	1,047	118	0,970	0,0085
2004	1,11	130,97	0,943	0,0076
2005	1,095	143,41	1,014	0,0070
2006	1,062	152,3	1,031	0,0066
2007	1,178	179,41	0,902	0,0056
2008	1,221	219,06	0,965	0,0046
2009	1,042	228,26	1,172	0,0044
2010	1,13	257,93	0,922	0,0039
2011	1,102	284,24	1,025	0,0035
2012	1,14	324,03	0,967	0,0031

Эх үүсвэр: Монгол Улсын статистикийн эмхтгэл, 1995, 1998, 2000, 2003, 2005, 2007, 2011

Хүснэгт 1-ийн эхний багананд бид Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ноос статистикийн жил бүрийн эмхтгэлд гаргасан хэрэглээний үнийн жил бүрийн өсөлтийн хэлхээ индексийг бүхэл тоогоор харуулсан. Хүснэгтээс харахад манай оронд инфляцийн цэвэр өсөлт 1991 онд өмнөх 1990 оныхоос 52 хувь, 1992 онд өмнөх оныхоосоо бүр 325 хувь, 1993 онд 183 хувьд хүрч гипер инфляци явагдаж байсан байна. Энэ нь 1991 оны 1 дүгээр сарын 16-нд тэр үеийн Засгийн газраас “алдартай” 20 дугаар

тогтоолыг гаргаж, төгрөгийн ханшийг шууд 2 дахин унагасан билээ. Дээр нь олон жил хүчээр зохиомлоор барьж байсан өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн, барааны үнийг чөлөөлсөн нь гипер инфляци үүсэх гол шалтгаан болсон байдаг.

Хүснэгтийн хоёр дахь багананд хэлхээ индексээ ашиглан суурь онтой харьцуулсан өсөлтийн индексийг бүхэл тоогоор харуулж, Зураг 1-д дүрслэн харуулав.



Эх үүсвэр: Хүснэгт 1-ийн 2-р баганы индекс

Инфляцийн өсөлт 2007 оноос хойш сүүлийн 6 жилд 2009 оноос бусад онд дандаа 2 оронтой тоогоор өсч ирсний дотор 2012 онд бүр 14 хувиар нэмэгдсэн байна. Энэ бол 2008 оны сонгуулиар иргэдэд бэлэн мөнгө амлан гарч ирж, түүнийгээ хэрэгжүүлсэн, дээр нь хавтгайрсан халамжийн бодлого явуулсан улс төрийн хүчнүүд бэлэн мөнгөний нийлүүлэлтийг эрс нэмэгдүүлж, төгрөгийн худалдан авах чадварыг сулруулж, улс орны макро эдийн засгийн тогтворгүй байдлыг хэрхэн бий болгосныг харуулсан баримт юм. Уг нь зах зээлийн эдийн засгийн нөхцөлд төрийн нэн тэргүүнд гүйцэтгэх үүргийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах явдал гэж үздэг боловч манай орны хувьд засаглалын хариуцлагагүй байдлын улмаас энэ үүргээ туйлын хангалтгүй биелүүлсээр ирсэн нь харагдаж байна.

Суурь оноос тооцсон өсөлтийн индекс ихээхэн сонирхолтой дүгнэлт хийх боломж олгож байна. Тухайлбал, 1990 оны нэг төгрөг 2012 оны 11 сарын эцсийн байдлаар 321 төгрөг 48 мөнгөтэй тэнцэх ханштай болжээ. Төгрөгийн ханш энэ хугацаанд 321 дахин буурч, 1990 оны нэг төгрөг одоо 0,3 мөнгөтэй тэнцүү болсныг сүүлийн баганаас харж болно.

Дээрх тооцоог үндэслээд махны үнийн өөрчлөлтийг авч үзье. 1990 оноос өмнө 1-р зэргийн хонины 1 кг мах 7 төгрөг 50 мөнгөний үнэтэй байсныг ахмад үеийнхэн одоо ч мартаагүй байгаа. Одоогийн ханшаар

бол $7,50 \times 321,48 = 2411,1$ буюу 2 мянга 411 төгрөг болж байна. Тэгвэл одоо 1 кг хонины мах 5,5 мянган төгрөг буюу 2 дахин өндөр байгаа билээ. Тэгэхлээр махны үнэ 1990 оноос өмнө төгрөгийн ханшны сулралыг харгалзан үзвэл одоогийнхоос 2 дахин хямд байсан байна.

Одоо бид цалин хөлсний өсөлт дээр баримжаа тооцоог хийе. 1990 оны үед дээд боловсролтой залуу ажилтан яам, газарт 650-700 төгрөг, ахлах мэргэжилтнүүд 750-800 төгрөг, хэлтсийн дарга нар 850-900 төгрөг, орлогч сайд нар дунджаар 1100-1200 төгрөгийн цалин хөлс авч байсан билээ. Одоогийн ханшаар бол тэр үеийн залуу ажилтнууд 209-225 мянган төгрөг, ахлах мэргэжилтнүүд 241-257 мянган төгрөг, хэлтсийн дарга нар 273-289 мянган төгрөг, орлогч сайд нар 353,6-385,8 мянган төгрөгийн цалин авч байжээ. Одоо жинхэндээ яам, агентлагуудад залуу ажилтнууд доод тал нь 450 мянгаас цалинжиж байгаа нь өнгөрсөн 23 жилд бодит цалин 2 дахин нэмэгдсэнийг харуулж байна.

Төгрөгийн худалдан авах чадварын индексийг тодорхойлсон тул одоо хүн амын орлого, хэрэглээтэй холбоотой бүх үзүүлэлтүүдийг зэрэгцүүлэх үнээр үнэлж, дүгнэлт хийх боломжтой болж байна.

Эхлээд бид Монгол Улсын өрхийн дундаж орлогыг хэрэглээний үнийн индексээр зэрэгцүүлэх үнэд шилжүүлье.

Нэг өрхийн дундаж мөнгөн орлогыг 1990 оны үнэд шилжүүлэхдээ Хүснэгт 1-ийн 2 дугаар баганад харуулсан хэрэглээний үнийн суурь онтой харьцуулсан индексийг ашиглан тооцож, үр дүнг Хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2-с харахад 1990-2011 оны хооронд нэг өрхийн дундаж мөнгөн орлого 1990 оны үнээр тооцвол 1,8 дахин буюу өнгөрсөн 21 жилд 83,7 хувь өсчээ. Монгол өрх айлын дундаж орлого, амьжиргаа өнгөрсөн 21 жилд 1,8 дахин дээшилсэн нь

бас ч үгүй чамлахааргүй ололт юм. 2011 онд манай орны нэг өрхийн дундаж мөнгөн орлого оны үнээрээ 503,9 мянган төгрөг байсан нь 1990 оны үнээр бол 1773 төгрөг боллоо гэсэн үг юм.

Эдийн засгийн бодит өсөлт болон өрхийн мөнгөн орлогын бодит өсөлтийн хоорондын харьцааг авч үзвэл ихээхэн сонирхолтой байх болно. Энэ харьцаа нь эдийн засгийн өсөлтийн үр дүн нь хүн амын бодит орлого, амьдралд хэр наалдаж үлдсэнийг баримжаалах боломж олгоно.

Хүснэгт 2. Нэг өрхийн дундаж мөнгөн орлого, төгрөгөөр


Он	Оны үнээр	1990 оны суурь үнээр	Мөнгөн орлогын бодит өсөлт, 1990=1
1990	965	965	1
1991	949	621	0,644
1992	2953	455	0,472
1993	8187	446	0,462
1994	20235	663	0,687
1995	33025	706	0,732
1996	45916	679	0,704
1997	56218	690	0,715
1998	66492	770	0,798
1999	68563	722	0,748
2000	82859	807	0,836
2001	102113	921	0,954
2002	124930	1109	1,149
2003	144354	1223	1,268
2004	144127	1100	1,140
2005	150208	1047	1,085
2006	173477	1139	1,180
2007	239179	1333	1,381
2008	325270	1485	1,539
2009	354967	1555	1,612
2010	387099	1501	1,555
2011	503936	1773	1,837

Эх үүсвэр: Монгол Улсын статистикийн эмхтгэл, 1995, 1998, 2000, 2003, 2005, 2007, 2011

Зураг 2-оос харахад сүүлийн 21 жилд манай орны нэг өрхийн дундаж мөнгөн орлогын бодит хэмжээний өсөлт эдийн засгийн өсөлтөөс ихэнх тохиолдолд хоцорч байжээ. Харин 2000 оноос хойш хүн амын бодит орлого нэлээд өсч, 2002-2003 онд 1990 оны сууриас тооцсон эдийн засгийн

өсөлтөөсөө давж гарсан боловч 2004 оноос 2006 он хүртэл өрхийн бодит орлогын өсөлтийн хурд нь буурч, эдийн засгийн өсөлт, өрхийн орлогын өсөлтийн хооронд урьд онуудын адил зааг гарсан (дэлгэрэнгүй тоо мэдээлэл, тооцоог Хавсралт 1-ээс харна уу) байна.

Зураг 2. ДНБ болон нэг өрхийн дундаж мөнгөн орлогын өсөлт, 1990=100, хувиар



Эх үүсвэр: Монгол Улсын статистикийн эмхтгэл, 1995, 1998, 2000, 2003, 2005, 2007, 2011

Эндээс эдийн засгийн өсөлтийн үр дүн нь хүн амын бодит орлого, амьдралд тэр бүр шууд тусгалаа олохгүй, өрхийн дундаж орлогын бодит хэмжээ сүүлийн 22 жилд эдийн засгийн өсөлтөөс доогуур өсөлттэй байжээ.

Одоо бид ядуурлын шугам буюу амьжиргааны доод түвшинг 1999 оноос хойш хэрхэн тооцсоныг авч үзье.

Ядуурлын түвшинг тооцохдоо амьжиргааны доод түвшинг ядуурлын шугам болгон авч түүнээс доогуур хэрэглээтэй хүн амын нийт хүн амд эзлэх хувиар гаргадаг. Тэгэхлээр манай орны хувьд ядуурлын түвшинг тодорхойлоход ядуурлын шугам маш чухал үүрэгтэй байдаг. Тэгвэл ядуурлын шугамын өсөлтөнд инфляци хэрхэн нөлөөлснийг судлаж үзье.

Монгол Улсын Засгийн газраас 1991 оноос эхлэн “Хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшин”-г тогтоон мөрдөж, 1991-1996 онд хот, хөдөөгийн ялгаатай байдлаар, 1997 оноос эхлэн бүс нутгаар тогтоож ирсэн (Хүснэгт 3).

УИХ-аас 2008 онд батлалсан “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” Монгол Улсын хуулиар ҮСХ нь хүн

амын амьжиргааны доод түвшинг жил бүр зарлаж байх үүрэг хүлээсэн. Мөн Монгол Улсын “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” хуулийн 5 дугаар зүйлд “... хүн амын амьжиргааны доод түвшинг хэрэглээний доод хэмжээг үндэслэн Үндэсний Статистикийн газар тодорхойлно” гэж заасан. Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” Монгол Улсын хуулийн 4 болон 5 дугаар заалтуудыг хэрэгжүүлэх үүднээс хэрэглээний доод хэмжээг үндэслэн манай орны нөхцөлд хүн амын амьжиргааны доод түвшинг бүсийн ялгавартайгаар тодорхойлох аргачлалыг 1998 онд боловсруулж, хүн амын амьжиргааны доод түвшинг шатахууны үнийн бүсээр тодорхойлох болсон. Энэ аргачлалыг Үндэсний статистикийн газрын даргын 1998 оны тушаалаар байгуулсан (тус газрын дэд даргаар ахлуулсан) ажлын хэсэг боловсруулсан байна. Энэхүү ажлын хэсэг УИХ-ын Хяналт шалгалтын хэлтэс, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам (хуучин нэрээр), Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн газар болон Үндэсний статистикийн газрын Нийгмийн статистикийн хэлтсийн ажилтнуудаас бүрдэж байжээ.

Хүснэгт 3. Хүн амын амьжиргааны доод түвшин, бүс нутгаар, 1999-2001, төгрөгөөр

Бүсүүд	Аймгууд	1997*	1999	2000	2001
Өрнөд	1. Баян-Өлгий 2. Говь-Алтай 3. Завхан 4. Увс 5. Ховд	9720	14100	15300	18200
Дорнод	1. Дорнод 2. Сүхбаатар 3. Хэнтий	9254	14500	16300	19900
Өмнөд	1. Говьсүмбэр 2. Дорноговь 3. Дундговь 4. Өмнөговь	9340	15600	15800	19300
Дундад	1. Архангай 2. Баянхонгор 3. Булган 4. Өвөрхангай 5. Хөвсгөл	9420	13800	14700	18200
Төв-1	1. Сэлэнгэ 2. Төв	9031	16400	16800	
Төв-2	1. Дархан-Уул 2. Орхон	10380			
Төв-3	1. Улаанбаатар	10400	17600	19300	23600

* Засгийн газраас баталсан.

“Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлд зааснаар “... хүн амын амьжиргааны доод түвшин гэж хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг, хэрэглээний доод хэмжээ гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэглээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо, хэмжээг” ойлгоно гэж тодорхойлжээ.

Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлохдоо дэлхийн хөгжиж байгаа орнуудад өргөн хэрэглэж

байгаа хэрэглээний сагсаар тооцдог аргыг өөрийн орны онцлогт тохируулан хэрэглэж байна. Хүн амын ядуу хэсгийн хэрэглээний сагс нь хүнсний ба хүнсний бус бараа, үйлчилгээнээс бүрдэнэ. Энэхүү сагсанд тансаг чамин хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг огт оруулдаггүй бөгөөд өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны ядуу амьжиргаатай өрхийн түгээмэл хэрэглэдэг хүнсний болон хүнсний бус бараа, бүтээгдэхүүнээр сагсыг бүрдүүлдэг.

Энэхүү аргачлалын дагуу тодорхойлсон хүн амын амьжиргааны доод түвшинг 2002-2010 оноор Хүснэгт 4-т харуулав.

Хүснэгт 4. Хүн амын амьжиргааны доод түвшин, бүс нутгаар, 2002-2010, төгрөгөөр

Он	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар
2002	19200	19100	19700	20200	24600
2003	19500	19900	19800	20500	25300
2004	20200	20600	20600	21200	26500
2005	23200	22600	22300	25000	30000
2006	37000	38300	39000	34800	42800
2007	54700	54600	56700	51800	60100
2008. II	70700	706900	73100	65600	73300
2008. X	94300	89000	90800	85100	94800
2009	96100	90600	91200	86300	101100
2010	97000	91500	91700	90900	101600
2011	104300	105100	106600	103500	118100
2012	115600	116800	117500	113000	126500

Эх үүсвэр: Монгол Улсын статистикийн эмхтгэл, 2000, 2003, 2005, 2007, 2011

Энэхүү үзүүлэлт нь сард өрхийн нэг гишүүнд ногдох хэрэглээний доод хэмжээг мөнгөн дүнгээр илэрхийлдэг. Айл өрхийн сарын хэрэглээ нь энэ хэмжээнд хүрдэггүй бол (ядуурлын шугамаас доош орсон тул) ядуу өрхөд хамаардаг.

Хүснэгт 5-д хэрэглээний үнийн өсөлт болон Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны доод түвшинг харуулав. 2008 онд хүн амын амьжиргааны доод түвшинг ҮСХ тухайн жилийн 2 болон 10 дугаар сард

2 удаа зарласан байдаг.


Хүснэгтийн сүүлийн 2 багананд хэрэглээний үнийн болон хүн амын амьжиргааны доод түвшний суурь 1999 онтой харьцуулсан өсөлтийг харуулав. Эндээс 1999-2012 оны хооронд хэрэглээний үнэ 4,2 дахин өссөн байхад харин ҮСХ-ноос зарлаж ирсэн хүн амын амьжиргааны доод түвшин 7,2 дахин өссөн нь харагдаж байна. Үүнийг Зураг 3-с бүр тодорхой харж болно.

Хүснэгт 5. Хэрэглээний үнийн индекс болон хүн амын амьжиргааны доод түвшин (ХААДТ), 1999-2012 оноор

Он	ХҮИ, жил бүрийн өсөлтийн индекс	ХААДТ, төгрөг	ХҮИ, 1999=100	ХААДТ, 1999=100
1999	1,1	17600	100,0	100,0
2000	1,081	19300	108,1	109,7
2001	1,08	23600	116,7	134,1
2002	1,016	24600	118,6	139,8
2003	1,047	25300	124,2	143,8
2004	1,11	26500	137,9	150,6
2005	1,095	30000	150,9	170,5
2006	1,062	42800	160,3	243,2
2007	1,178	60100	188,8	341,5
2008. II	1,221	73300	230,6	416,5
2008. X	1,221	94800	281,5	538,6
2009	1,042	101100	293,4	574,4
2010	1,13	101600	331,5	577,3
2011	1,102	118100	365,3	671,0
2012	1,14	126500	416,4	718,8

Эх үүсвэр: Монгол Улсын статистикийн эмхтгэл, 2000, 2003, 2005, 2007, 2011

Зураг 3. Хэрэглээний үнэ болон ҮСХ-ноос зарласан Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны доод түвшингийн (ХААДТ) өсөлт, 1999=100, хувиар



Эх үүсвэр: Хүснэгт 5-ын сүүлийн 2 баганы тоо мэдээг ашиглав.

Зураг 3-с харахад 2005 оноос эхлээд ҮСХ-ноос зарласан хүн амын амьжиргааны доод түвшин инфляцийн өсөлтөөс ихээхэн давж, хурдтайгаар огцом нэмэгдэж ирсэн байна. Энд гол нь хүн амын амьжиргааны доод түвшинг тооцохдоо хэрэглээний үнийн өсөлтийг харгалзаагүй, жил бүр ядуурлын сагсны үнийг тусгайлан цуглуулж тооцож ирсэн нь ноцтой алдаа болжээ. Олон улсын жишгээр бол *benchmark* буюу суурь

оноор сагсанд авсан бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг нэг сайн судлаад дараагийн 5 жилд нь ядуурлын шугамыг зөвхөн хэрэглээний үнийн индексээр засварлаад явдаг. Гэтэл манайд үүнийг хийдэггүй жил бүр тусгайлан үнэ цуглуулж, тооцож ирсэн. Хэрвээ 2004 оноос хойш зарлагдсан ядуурлын шугамыг ХҮИ-ээр засварлавал ямар байхыг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 6. Хүн амын 2004-2012 оны амьжиргааны зарлагдсан доод түвшинг хэрэглээний үнээр индексжүүлсэн тооцоо, ядуурлын шугам, тэдгээрийн зөрүү

Он	Хэрэглээний үнийн жил бүрийн өсөлтийн индекс	Хэрэглээний үнээр индексжүүлсэн ХААДТ, төгрөг	Зарлагдсан ХААДТ, төгрөг	Зарлагдсан ХААДТ болон индексжүүлсэн ХААДТ-ны зөрүү, төгрөг	Ядуурлын тооцоонд ашигласан ядуурлын шугам	Ядуурлын ашигласан шугам ба индексжүүлсэн ХААДТ-ны зөрүү, төгрөг
2004	1,11	26500	26500	0		
2005	1,095	29018	30000	982		
2006	1,062	30817	42800	11983		
2007	1,178	36302	60100	23798	62494	18169-26192
2008. II	1,221	44325	73300	28975		
2008. X	1221	44325	94800	50475		
2009	1,042	46186	101100	54914	65253	19067
2010	1,13	52191	101600	49409	88156	35965
2011	1,102	57514	118100	60586	97975	40461
2012	1,14	65566	126500	60934		

Эх үүсвэр: Статистикийн эмхтгэл болон судлаачийн тооцоо. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүн, 2007-2008, 2009, 2010, 2011

Хүснэгт 6-аас харахад 2012 оны Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны доод түвшин ХҮИ-ээр засварласан шугамаас бараг 2 дахин өндөр тооцогдож, тухайн үедээ зарлагджээ. Хэрэв ядуу хүмүүсийн хэрэглэсэн бараа, үйлчилгээний үнэ улсын дундаж үнийн өсөлтөөс 2 дахин өндөр байсан тохиолдолд энэхүү зарласан хүн амын амьжиргааны доод түвшинг хүлээн зөвшөөрч болох юм. Гэтэл ийм явдал амьдралд байх боломжгүй билээ. Нөгөө талаар ядуурлын 2007-2008 оны болон түүнээс хойшхи хугацааны судалгаануудад ашигласан ядуурлын шугамын түвшин ХҮИ-ээр засварласан ХААДТ-ээс бас л өндөр тооцогджээ. Тухайлбал, 2010 оны ядуурлын судалгаанд ашигласан ядуурлын шугам ХҮИ-ээр засварласан ХААДТ-өөс 36 мянган төгрөгөөр, 2011 оных 40,5 мянган төгрөгөөр өндөр байна. *Энэ бол маш ноцтой асуудал юм. Ядуурлын тооцоонд ашигласан ядуурлын шугам ХҮИ-ээс хурдан өсөлттэй дээшилсний улмаас энэхүү шугамаас доогуур амьжиргаатай хүн амын тоо буурахгүй нь ойлгомжтой бөгөөд энэ нь Монгол Улсад ядуурал олон жил буурахгүй байсаар ирсэн нэг гол шалтгаан болсон гэж дүгнэж болохоор байна.*

Манай орны хувьд сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт гарч байгаа боловч ядуурал төдийлөн буураагүй явсаар ирсэн. Одоо эргээд харахад ядуурлын шугамаа үндэслэлгүй өсгөж тооцсон тул ядуурлын хамралт болон бусад үзүүлэлтүүд үнэн зөв тооцогдсон эсэхэд эргэлзэхэд хүрч байна.

ҮСХ, Дэлхийн банкнаас 2009 онд хамтран гаргасан илтгэлд 2002-2003 оныг дамжин явагдсан ядуурлын судалгааны дүнгээр ядуурлын хамралтын хүрээг 36,1 хувь, харин 2007-2008 оныг дамжин хийгдсэн судалгаагаар дээрх хувь 35,2 болж бага зэрэг буурсан билээ. Үүний дараагаар 2010 онд Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар 2007-2008 оныг дамжин хийгдсэн судалгааг үндэслэн өөрсдийн бие даасан тооцоог хийсэн бөгөөд ингэхдээ ядуурлын хамралтын хүрээг 14,8

хувь гэж шинэчлэн тооцсон байдаг. Энэхүү тооцоогоор бол Монгол дахь ядуурал 2002-2003 оныхоос (36,1 хувь) эрс буурсан болж байгаа юм. Дэлхийн банк энэхүү тооцоогоо өмнөх онуудын ядуурлын тооцооны ядуурлын шугамууд нь харьцуулахааргүй өөр өөр байсан тул түүнийг засварлан хийсэн байна. Ингэхээр Монгол дахь Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газар манай ядуурлын шугам үндэслэлгүйг олж мэдсэн бололтой байна.

ҮСХ 2010 оны ядуурлын хамралтын хүрээг 39,2 хувь гэж зарласан байсан. Сүүлийн 3 жилд ҮСХ, Дэлхийн банк хоёр Монголын хүн амын ядуурлын тооцооны талаар нэлээд маргалдаж, санал зөрөлдсөний эцэст хамтарсан тооцоо хийж, 2011 оны ядуурлын түвшинг 2012 оны 4 дүгээр сард 29,8 хувь гэж зарласан.

Манай ядуурлын тооцоонд гадаадын байгууллагууд ч бас байр сууриа илэрхийлжээ. Тухайлбал, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын илтгэлд Дэлхийн банкны тооцоог иш татаад Монголд сүүлийн 5 жилд ядуурал мэдэгдэхүйц буурсан боловч ажил эрхлэлтийн өсөлт бага байгаа нь итгэмээргүй байна гэжээ. Мөн НҮБ-ын Хүүхдийн сангийн мэргэжилтэн Монгол Улсын эдийн засгийн өндөр өсөлт, мөнгөний бус үзүүлэлтүүд сайжирсан явдал нь ядуурал буурсан байх үндэстэй, Дэлхийн банкны тооцоо итгэл төрүүлэхүйц үнэмшилтэй байна гэж үзжээ.¹

Энэ бүхнээс харахад ҮСХ-ноос гаргасан ядуурлын үзүүлэлтүүдийн тооцоог эргэж нягтлах шаардлагатай нь харагдаж байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

1990-2012 оны хооронд төгрөгийн дотоодын худалдан авах чадвар 324 дахин унаж, 1990 оны нэг төгрөг өнөөдөр 0,3 мөнгөтэй тэнцэхээр суларчээ. 2012 оны 324 төгрөг нь 1990 оны нэг төгрөгтэй тэнцэх ханштай байна.

¹ Saurabh Sinha, Poverty estimation in Mongolia: Framing the issues, 15 March, 2012

Төрөөс 2008 оноос хойш сонгуулийн амлалтаар хүн амд бэлэн мөнгө тарааж, дээр нь хавтгайрсан халамжийн бодлого явуулсны улмаас төгрөгийн худалдан авах чадварыг улам сулруулж, улс орны макро эдийн засгийн тогтворгүй байдал үүсээд байна. Сүүлийн жилүүдэд инфляцийн өсөлт жил бүр 2 оронтой тооноос буурахгүй байна.

Өрхийн нийгэм, эдийн засгийн түүвэр судалгааны дүнгээр гарсан 1990-2011 он хоорондын өрхийн дундаж мөнгөн орлогын хэмжээг зэрэгцүүлэх үнээр тооцож үзэхэд манай өрхийн дундаж мөнгөн орлогын бодит хэмжээ 2011 онд 1990 онтой харьцуулахад 1,8 дахин өссөн байна. Сүүлийн 21 жилд монгол өрхийн орлогын бодит өсөлт чамлахааргүй байжээ. Гэхдээ өрхийн дундаж орлогын өсөлт эдийн засгийн өсөлтөөс хоцрогдонгуй хурдтай өсч иржээ.

2000-2012 оны хооронд ҮСХ-ноос зарласан хүн амын амьжиргааны доод түвшинг ХҮИ-ээр засварлан индексжүүлж үзэхэд 2005 оноос хойш бодит байдлаас хурдан өсч иржээ. Өөрөөр хэлбэл, ҮСХ-ноос албан ёсоор зарлагдсаар ирсэн хүн амын амьжиргааны доод түвшин ХҮИ-ээс бараг 2 дахин хурдан нэмэгджээ. ҮСХ нь хуулиар хүлээсэн үүргийн дагуу хүн амын амьжиргааны доод түвшинг тооцохдоо үндэслэл муутай өндрөөр тооцож зарласан нь судалгаанаас харагдлаа.

Зарлагдсан ядуурлын шугам ингэж хурдан дээшилсний улмаас энэхүү шугамаас доогуур

амьжиргаатай хүн амын тоо буурахгүй нь ойлгомжтой бөгөөд энэ нь Монгол Улсад ядуурал олон жил буурахгүй байсаар ирсэн нэг гол шалтгаан болсон байна.

ҮСХ-ноос зарласаар ирсэн хүн амын хүн амын амьжиргааны доод түвшинг дахин засварлаж зарлах, ядуурлын үзүүлэлтүүдийн тооцоог эргэж нягтлан үзэхийг санал болгож байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол хэл дээр

УИХ, 2008. “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” Монгол Улсын хууль, 2008, Улаанбаатар

ҮСХ, 1995 - 2011. Монгол Улсын статистикийн эмхтгэл, 1995, 1998, 2000, 2003, 2005, 2007, 2011, Үндэсний Статистикийн хороо, Улаанбаатар

ҮСХ, 2007 - 2011. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүн, 2007 - 2008, 2009, 2010, 2011, Үндэсний Статистикийн хороо, Улаанбаатар

Англи хэл дээр

Saurabh Sinha, 2012. Poverty estimation in Mongolia: Framing the issues, 15 March, 2012, Ulaanbaatar

Бусад мэдээлэл

http://www.wikiprogress.org/index.php/Purchasing_power_parity